



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 23 өдөр

Дугаар

A/371

Арвайхээр

┌ Дуудлага худалдаа зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолын “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 3.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 30 дугаар тогтоол, 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагуудаас ирсэн санал, МОНГОЛ САНХҮҮ БҮРТГЭЛ ХХК-ын үндсэн хөрөнгийн үнэлгээний тайланг үндэслэн Тарагт сумын Ерөнхий боловсролын сургуулийн хөрөнгөнд бүртгэлтэй Хуучин дотуур байрны барилгыг 2020 м.кв газрын хамт 4,534,469.76 (дөрвөн сая таван зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг далан зургаа мөнгө), Бүрд сумын Ерөнхий боловсролын сургуулийн хөрөнгөнд бүртгэлтэй Хуучин дотуур байрны барилгыг 628,3 м.кв газрын хамт 1,754,200.93 (нэг сая долоон зуун тавин дөрвөн мянга хоёр зуун төгрөг ерэн гурван мөнгө), Есөнзүйл сумын Ерөнхий боловсролын Тахилга бага сургуулийн барилгыг 250 м.кв газрын хамт 712,817.08 (долоон зуун арван хоёр мянга найман зуун арван долоон төгрөг найман мөнгө), Дотуур байр гал тогооны барилгыг 140 м.кв газрын хамт 407,560.14 (дөрвөн зуун долоон мянга таван зуун жаран төгрөг арван дөрвөн мөнгө), 440 хүүхдийн хичээлийн байрны барилгыг 2000 м.кв газрын хамт 5,053,951.23 (таван сая тавин гурван мянга есөн зуун тавин нэгэн төгрөг хорин гурван мөнгө), Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газрын Зочид буудлын барилгыг 250 м.кв газрын хамт 603,190.18 (зургаан зуун гурван мянга нэг зуун ерэн төгрөг арван найман мөнгө), Соёлын төвийн хуучин барилгыг 400 м.кв газрын хамт 1,085, 672.34 (нэг сая наян таван мянга зургаан зуун далан хоёр төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгөөр үнэлж дуудлага худалдаагаар худалдсугай.

2. Газрын биржийн цахим системийг ашиглан дуудлага худалдааг 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсугай.

3. Хөрөнгийн дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, орлогыг “Орон нутгийн өмч худалдсаны орлого” дансанд төвлөрүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

011100793